



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 09 сарын 05 өдөр

Дугаар А/551

Арвайхээр

**Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн 100 дугаар зөвлөмжийн дагуу Арвайхээр сумын 5 дугаар сургуульд тавилга, техник хэрэгсэл нийлүүлэх тендерийн 1 дүгээр багцыг 89790000 (наян есөн сая долоон зуун ерэн мянга) төгрөгөөр Хашхан ХХК-иар, 2 дугаар багцыг 53900000 (тавин гурван сая есөн зуун мянга) төгрөгөөр Тэрэмбаян ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Гэрээ байгуулан, бараа нийлүүлэлтийн явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг Арвайхээр сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургууль (Г.Зууннаст)-д даалгасугай.

3. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг Арвайхээр сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн нягтлан бодогч (Н.Сэдэд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100992